

Нэг. Байгууллагын түүх

Анх Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх захиргааны 1992 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 183 дугаар тогтоолоор Нийслэлийн Найрамдлын районы 97 дугаар сургууль байгуулагдан сургалтын үйл ажиллагаа нь эхэлсэн түүхтэй.



1992 оны 08 дугаар сарын 05-нд (хуучнаар Зөвлөлт холбоот улсын 8-р сургууль байсан) сургуулийн байрыг Шинжлэх Ухаан Боловсролын Яамны орлогч сайд н.Энхтүвшин, Боловсролын хэлтсийн дарга н.Батжаргал, 79-р сургуулийн захирал Г.Зодов, багш, Ш.Сэтэв нар протокол хөтлөн сургуулийн барилгыг хүлээлцсэн байна.

1992 оны 08 сарын 10-нд анхны захирлаар Г.Нармандах, аж ахуйн даргаар М.Ганбаатар нар томилогдон ирж үйл ажиллагаа эхэлсэн ба улмаар 08 сарын 15-нд анхны бага ангийн эрхлэгчээр Н.Наранцэцэг, дунд ангийн эрхлэгчээр Ж.Доржсүрэн, нягтлан бодогчоор Б.Нацагдорж нар ажиллаж эхэлсэн байна.

1992-1993 оны хичээлийн жилд 53 багш, 16 ажилчин, 1217 сурагчтайгаар сургалт хүмүүжлийн ажлаа эхэлсэнээс хойш хичээлийн 1, 2 байртай болж сургалтын ажлаа үргэлжлүүлж байгаа билээ.

Хичээлийн 1 дүгээр байр 964 хүүхдийн хүчин чадалтай, лаборатори, 5 кабинет, биеийн тамирын зал 1, урлаг зал 1, цайны газартайгаар ашиглалтанд орсон.

2007 оны 04 сард Япон Монгол Улсын Найрамдлын хамтын ажиллагааны хүрээнд Японы ард түмний буцалтгүй тусламжаар хичээлийн 2 дугаар байрны өргөтгөлийг хүлээлгэн өгсөн. Хичээлийн 2 дугаар байр нь 240 хүүхдийн хүчин чадалтай, хичээлийн 8 анги, хувцасны өлгүүр, спорт талбайтай ашиглалтанд орсон.

Одоогийн байдлаар бага ангийн 31, дунд ангийн 19, ахлах ангийн 11, нийт 61 бүлэгт 1-5-р ангийн 1041 сурагч, 6-9 анги ангийн 682 сурагч, 10-11 анги ангийн 341, нийт 2064 сурагчтай, 126 багш ажиллагсадтай, үүний 89 нь багш сурган хүмүүжүүлэгч. Мэргэжлийн багш нарын заах аргын 8 секц нэгдэлтэй. 40 хүний багтаамжтай уншлагын танхим, 10100 гаруй ном бүхий номын сантай. Урлаг, спортын 2 залтай, цайны газар, Хүүхэд хөгжлийн төв, технологийн сургалт, дадлагын төв, “Багш хөгжил төв” –тэйгээр сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байна.

Тус сургуулийн захирал Д.Мөнхбат нь Ардын боловсролын тэргүүний ажилтан, заах аргач зэрэгтэй, 2009 оноос эхлэн ажиллаж байна.

2012 онд Япон Улсын буцалтгүй тусламжаар “Өвсний үндэс” төсөл хөтөлбөрийн хүрээнд 135 сая төгрөгний барилгын дээвэр, сантехникийн шугамын засвар, бие засах газрын засварын ажлыг тус тус хийсэн. Сургалт хүмүүжлийн ажлыг чанартай явуулсаны үр дүнд сурагчдын мэдлэгийн түвшин сүүлийн таван жилийн дунджаар 85-90%-тай байна.

Тус сургуулийн хамт олон болон сурагчдын амжилт ололтоос дурьдвал:

- 1992-1993 оны хичээлийн жилд хотын багш нарын урлагийн наадамд сургууль багаараа тэргүүн байранд шалгарч байсан.

- 2006 онд Монгол улсын баатар сансрын нисгэгч Ж.Гүррагчаагийн нэрэмжит дүүргийн математикийн бодлогын уралдаанд амжилттай оролцож тэргүүн байранд шалгарсан.
- 2007, 2008 онд тус уралдаанд амжилттай оролцож багаараа II байранд шалгарсан.
- 2001-2002 оны хичээлийн жилд “Гимнастик”-ийн төрөлжсөн сургалттай ангийг нээж ажиллуулсан. Анги удирдсан багшаар Боловсролын тэргүүний багш С.Тунгалаг. Энэхүү ангиас Олон Улсын хэмжээний мастер - 2, Спортын мастер- 3, спортын дэд мастер 2 төрөн гарсны зэрэгцээ дүүрэг, хот, улс, олон улсын чанартай уралдаан тэмцээнүүдэд удаа дараа өндөр амжилтууд үзүүлж байсан.
- Тус сургуулийн сурагчдаас гар буудлагын спортын мастер - 1, жүдо бөхийн СМ – 1, боксын СМ -1, таэквонда СМ–1, дугуйн ОУХМ–1 төрөн гарсан төдийгүй эдгээр сурагчид дүүрэг, хот, улс, тив, дэлхийн чанартай тэмцээнүүдэд амжилттай оролцож алт, мөнгө, хүрэл медалиуд хүртэж байсан.
- 1997 оноос “Хаврын баяр” цэнгээнт бүжгийн улсын уралдаанд “Хөх яргуй” хамтлаг оролцож түүнээс хойш тасралтгүй өнөөг хүртэл залгамж халаа “Ягаан сарнай” хамтлаг амжилттай оролцож байна.
- 2003 онд Нийслэлийн Хүүхдэд ээлтэй байгууллагаар шалгарч байсан.
- 2007 оны Улсын тэргүүний шимтгэл төлөгч байгууллагаар шалгарч байсан
- 2007 онд Монгол улсын Боловсролын Их сургуулийн “Клиник сургууль” болсон.

Бидний бахархал

Манай алдартнууд

- Ж.Доржсүрэн - Монгол улсын Гавъяат багш
- О.Ваанчиг - Алтан гадас
- Г.Зодов, Д.Одсүрэн - Хөдөлмөрийн хүндэт медаль
- С.Тунгалаг - Хөдөлмөрийн хүндэт медаль

“Багш нарын мэргэжлийн үр чадвар шалгаруулах уралдаан”-д багш нарын гаргасан амжилтууд

Дүүрэгт:

- А.Даваацэрэн -1996-1997 оны хичээлийн жилд тэргүүн байр - мэргэжил биологи
- Е. Нямаа - 1999-2002 оны хичээлийн жилд тэргүүн байр – мэргэжил математик
- Г.Туул - 2002 оны хичээлийн жилд дэд аварга – мэргэжил түүх нийгэм
- С.Адмирал - 2002-2003 оны хичээлийн жилд тэргүүн байр – мэргэжил технологи
- Л.Уянга - 2003-2004, 2004-2005 онуудын хичээлийн жилд тэргүүн байр – мэргэжил орос, англи хэл
- Д.Үнэнбат - 2003-2004 оны хичээлийн жилд тэргүүн байр – мэргэжил биеийн тамир
- Д.Баттулга - 2007-2008 оны хичээлийн жилд тэргүүн байр – мэргэжил технологи
- С.Амаржаргал - 2007-2008 оны хичээлийн жилд тэргүүн байр – мэргэжил монгол хэл
- Б.Оюунбилэг - 2008-2009 оны хичээлийн жилд тэргүүн байр –мэргэжил түүх-нийгэм

Хотод:

- Е.Нямаа - 2000 онд тэргүүн байр мэргэжил математик
- Д.Үнэнбат- 2003-2004 оны хичээлийн жилд тэргүүн байр – мэргэжил биеийн тамир
- С.Амаржаргал - 2007-2008 оны хичээлийн жилд тэргүүн байр – мэргэжил монгол хэл
- Б.Оюунбилэг - 2008-2009 оны хичээлийн жилд тэргүүн байр – мэргэжил түүх-нийгэм

Сурган хүмүүжүүлэх уншлагад багш нарын гаргасан амжилтууд:

Дүүрэгт:

- Д.Баттулга 2008-2009 оны хичээлийн жилд III байр

Хотод:

- С.Оюунбат 1997-1998 оны хичээлийн жилд III байр
- Д.Янжиндулам 2003-2004 оны хичээлийн жилд II байр

Улсад:

- С.Оюунбат 1997-1998 оны хичээлийн жилд I байр

Багш нарын мэргэжлийн олимпиадад гаргасан амжилтууд:

Хотод:

- С.Амаржаргал 2003 онд Монгол хэл бичгийн хотын олимпиадад II байр, 2008 онд Багшийн их сургуулийн 80 жилийн ойд зориулсан улсын монгол бичгийн олимпиадад II байр эзэлсэн
- Л.Уянга 2005 онд орос хэлний багш нарын хотын олимпиадад I байр

Улсад:

- Х.Дэлгэржаргал 1999 онд Улсын Физикийн олимпиадын алтан медаль
- Л.Уянга 2004-2005 онд орос хэлний багш нарын улсын олимпиадад III байр, 2005 онд орос хэлний улсын X олимпиадад I байр. 2008-2009 онд англи хэлний багш нарын олимпиадад I байр.
- С.Амаржаргал 2003 онд Монгол хэл бичгийн улсын олимпиадад I байр, 2008 оны хотын олимпиадад II байр эзэлсэн, 2009 оны 5-р сард БСШУЯ-аас зохион явуулсан “Бурханы шашин –оюуны нандин өв” эссэ бичлэгийн уралдаанд IV байр.
- Д.Алтансүвд 2006-2007 оны хичээлийн жилд зохиогдсон монгол бичгийн улсын олимпиадаас алтан медаль хүртсэн.

Ажил, мэргэжлийн аварга багш нар

Дүүрэгт:

- Н.Наранцэцэг 2005 оны шилдэг сургалтын менежер
- С. Оюунбат 2005 оны шилдэг Нийгмийн ажилтан
- С.Амаржаргал 2007 оны мэргэжлийн аварга багш.
- Ч.Оюунгэрэл 2011 онд шилдэг сургалтын менежер

Хотод:

- С.Оюунбат 2003 оны Хотын шилдэг нийгмийн ажилтан, 2005 оны Нийслэлийн тэргүүний нийгмийн ажилтан

Улсад:

- С.Тунгалаг 2005 оны Улсын тэргүүний багш

Багш нарын гадаад улс орнууд дахь мэргэжил дээшлүүлэлт

- С.Оюунбат 2005 онд ХБНГУ-н Доберлуг хотын Боловсролын акедемид сургуулийн нийгмийн ажил мэргэжлээр мэргэжил дээшлүүлсэн, 2006 онд БНСУ-н Пусан хотноо олон улсын сургуулийн нийгмийн ажилтнуудын III хуралд төлөөлөгчөөр оролцсон.
- Э.Мандухай, Е.Нямаа нар 2005 онд Солонгос улсын Дэжун хотод мэргэжил дээшлүүлсэн.
- С.Дуламрагчаа, Х.Баярцэнгэл нар 2006 онд Японы Гакугей их сургуульд мэргэжил дээшлүүлсэн. /JICA-н олон улсын найрамдал төслийн хүрээнд/
- Д.Сэргэлэн 2007 онд “Суралцахуйг дэмжих” төслийн хүрээнд Япон улсад мэргэжил дээшлүүлсэн.

Сурагчдын амжилт

Сурлага:

- 2005 онд сурагч Санчир дүүрэгт алт, сурагч Эрдэнэмөнх мөнгөн медаль тус тус хүртэж хотод амжилттай оролцсон.
- 2005 онд сурагч Н.Амарзаяа сэтгэх чадварын олимпиадын дүүргийн аварга болж Эрдэнэт хотноо болсон улсын олимпиадад оролцож алтан медаль авсан.
- 1997 онд сурагч Ч.Мөнхцэцэг сургууль, дүүргийн математикийн олимпиадын аварга
- 2004 онд сурагч З.Санчир дүүргийн математикийн олимпиадын аварга
- Сурагч Наранбаатар Улаанбаатар хотод зохион байгуулсан хурдан бодолтын тэмцээнд алтан медаль.
- 1998 онд сурагч Ц.Нарантуяа хотын математикийн олимпиадад алтан медаль
- 1999- 2000 оны хичээлийн жилд сурагч Э.Онон монгол хэлний улсын олимпиадын алтан медаль
- 2008 онд сурагч Д.Саранцэцэг дүүргийн математикийн стандартын олимпиадын алтан медаль
- 2008-2009 онд сурагч Энхтүвшин монгол бичгийн олимпиадаас алтан медаль
- 2005-2008 онуудад “Усны үнэ цэнэ” эссэ бичлэгийн уралдаанд:
Сурагч Н.Батцэцэг алтан медаль
- 2008-2009 онд “Усны үнэ цэнэ” эссэ бичлэгийн уралдаанд:
Сурагч Баяржаргал алтан медаль
- 2002-2003 онд сурагч А.Дашцэрэн нийслэлийн газар зүйн олимпиадад I байр алтан медаль.

Спорт:

Спорт азробик

Олон улсын хэмжээний мастерууд:

1. Сурагч Э.Мөнх-Оргил
2. Сурагч Б.Хулан
3. Сурагч Н.Гарамханд

Спортын мастер

1. Сурагч Д.Сансарбат
2. Сурагч Б.Халиун
3. Сурагч Н.Намуунцэцэг
4. Сурагч Э.Мөнх-Оргил
5. Сурагч Э.Анхбаяр
6. Сурагч А.Мөнхтоого
7. Сурагч Н.Гарамханд
8. Сурагч П.Хулан

9. Сурагч Л.Эрдэнэсүвд

10. Сурагч Б.Сайнжаргал

Дэлхийн цомын аваргаас

1. 2003 онд Э.Мөнх-Оргил, Б.Хулан хосын төрөлд мөнгөн медаль
2. Д.Сансарбат, Б.Уранбайгаль хосын төрөлд хүрэл медаль
3. Э.Мөнх-Оргил эрэгтэй ганцаарчилсан төрөлд хүрэл медаль
4. 2007 онд Ч.Золбоо дэлхийн аваргаас VII байр, улсын 12 удаагийн аварга, хотын 16 удаагийн аварга
5. Олон улсын тэмцээнээс сүүлийн 5 жилд алт 26, мөнгө 20, хүрэл 24-ийг хүртсэн байна

Шатар:

- Сурагч Г.Сайханзаяа спортын дэд мастер, Дэлхийн аваргаас дурсамж алтан медаль
- Сурагч Б.Буяннэмэх Хүүхдийн их наадмаас мөнгө, хүрэл медаль, Цодгор хүү 2007 алт.
- Сурагч Б.Эрдэнэтуяа Өсвөрийн шатарчдаас 2006, 2007 улсын аварга, хошой хүрэл, Цодгор хүү алт мөнгө, Их мастерын гараас алт. 2008 онд улсын аваргын алтан медаль, Их мастерын гараа улсын уралдааны алтан медаль

Ширээний теннис:

- Сурагч Б.Хадаа улсын аварга.

Хөл бөмбөг:

- 2009 оны хотын аварга. Дунд нас мөнгө, ахлах нас хүрэл, бага нас алт.

Дугуй:

- Сурагч Б.Болд-Эрдэнэ Олон улсын хэмжээний мастер.

Бокс:

- Сурагч Э.Түвшинням 2008 оны Залуучудын боксын аварга. Спортын мастер. Олон улсын мөнгөн медаль.
- Сурагч Т.Түвшинтөгс 2002 оны улсын аварга.

Гар буудлага:

- Сурагч Б.Амаржаргал спортын мастер.

Нисэх загвар:

- Сурагч Э.Намдүү улсын аварга. Олон улсын аваргаас алт, мөнгө

Хоккей:

- Сурагч Б.Мөнхболд улсын аварга.
-

Жүдо:

- Сурагч Ж.Гүндэгмаа улсын аварга. 2001-2002 он. Азийн аварга.
- Сурагч Э.Цэнд-Аюуш Самбо жудогийн 2004 оны улсын аварга.

Таеквондо:

- Сурагч С.Отгонбаатар 2001 оны олон улсын тэмцээнээс алтан медаль, олон улсын болон үндэсний аварга шалгаруулах тэмцээний алтан медальт хар бүс дантай. 2001 оны Нийслэлийн тэргүүний сурагч.
- Сурагч А.Мөнхнаст спортын мастер

Уран нугаралт:

- Сурагч Г.Нямгэрэл 2006, 2008 оны улсын аварга.

Урлаг:

- Д.Цэцэгдарь “Уран жиргээ” уран уншлагын улсын уралдааны алт, мөнгө, хүрэл медальт
- Б.Тамир “Уран жиргээ” уран уншлагын улсын уралдааны алт, мөнгө, хүрэл медальт, монгол телевизийн “Найдвар” нэвтрүүлгийн хөтлөгч
- Н.Учрал “Хүрэл тулга” яруу найргийн дүүргийн наадмын тэргүүн байр
- Цэнгээнт бүжгийн “Хөх яргуй” хамтлаг нийслэлийн хүүхдийн урлагын наадмын тэргүүн байр, “Солонго” теле их наадмын тэргүүн байр
- Цэнгээнт бүжгийн “Ягаан сарнай” хамтлаг нийслэлийн цэнгээнт бүжгийн уралдааны тэргүүн байр
- Реп бүжгийн “Балгас хотын танхай жаалууд 1, 2” багууд хот, улсын уралдаанд тэргүүн байр
- Сурагч н.Ууганбаяр монгол ардын бүжгийн төрлөөр Хүүхдийн урлагийн их наадмын алтан медаль
- Спорт - бүжгийн төрлөөр сурагч Ууганбаяр хосын хамт улс, олон улсын тэмцээнээс алтан меадль
- Спорт – бүжгийн төрлөөр
- Сурагч Б.Оюун “Одод болохын хүслэн” улсын уралдаанд удаа дараа амжилттай оролцож алтан медаль
- Сурагч Д.Хишигжаргал 2007, 2008 онд “Азийн цэцэгс” япон хятад дуу дуулаачдын улсын уралдааны алтан медаль

Хоёр. Хөмрөгийн баримтын түүх

Баянзүрх дүүргийн 97 дугаар сургууль анх үүсгэн байгуулагдсанаас хойш 1992-2012 оны байнга хадгалах нийт 172 хадгаламжийн нэгж /1992-2012 оны захирлын тушаал, жилийн төлөвлөгөө, тайлан, санхүүгийн тайлан тэнцэл зэрэг/ баримтууд сургуулийн архивт хадгалагддаг. Нийслэлийн Архивын сан хөмрөгт хадгалагддаг баримт байхгүй.

Иймд тус сургууль нь 1992 – 2012 оны байнгын баримтаар Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу нөхөн бүрдүүлэлт хийхээр архив, бичиг хэргийн ажилтан Д.Буянаа миний бие нийслэлийн Архивын газрын ажилтан Н.Цацралтуяагаас мэргэжил арга зүйн зааварчилгаа аван байгууллагын архивт хадгалагдаж буй 1992-2012 оны архивын баримтад 2013 оны 08 дугаар сарын 26-наас 2013 оны 12 дугаар сарын 11-нийг дуустал хугацаанд сургуулийн дотоод нөөц бололцоогоо ашиглан эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Тус сургуулийн архивын баримт нь анх хүлээн авахад данс, бүртгэлгүй, 1992-2011 оны санхүүгийн зарим баримтууд нь үдэж хавтаслагдсан удирдлагын болон зохион байгуулалтын баримтууд болох тушаал, ирсэн явсан бичиг, тайлан төлөвлөгөө зэрэг нь мөн үдэж хавтаслагдсан, бусад шалгалтын материал, сургалттай холбоотой баримтууд нь ангилж, цэгцлээгүй, үдэж хавтаслаагүй задгайгаар, 2009 оноос өмнөх баримтууд ихэвчлэн задгайгаар хадгалагдаж байсан.

Хэдий баримтуудыг үдэж хавтасласан боловч байнга, 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжээр ангилж төрөлжүүлээгүй, данс бүртгэл огт хөтөлж байгаагүй, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт огт байхгүй, баримтуудын бүртгэл байхгүй байсан. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргаж, баримтуудыг эмхэлж цэгцэлсний дараа баримтын бүрдлийг дурьдвал:

Баримтын бүрдэл:

- ✓ **Байнга хадгалагдах баримтын бүрдлийн хувьд:** Захирлын тушаал, хурлын тэмдэглэл, ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ, биелэлт, хичээлийн жилийн

ажлын төлөвлөгөө, тайлан, ирсэн, явуулсан бичиг, жилийн эцсийн дүнгийн нэгтгэл, сурагчдын дүнгийн “Б” маягт санхүүгийн жилийн эцсийн тайлан тэнцэл, үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын бүртгэл зэрэг баримтуудаас бүрдэж байна.

2008-2009 оны байнга хадгалах баримтын бүрдэл дутуу:

- ✓ Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, тооцоо
- ✓ Цалингийн карт, цалингийн тооцоо
- ✓ Санхүүгийн тайлан

Дээрх баримтуудын талаар 2009 онд ажиллаж байсан нягтлан бодогч Х.Сарантуяагаас лавлан асуухад дүүргийн төрийн санд тушаасан, авч өгнө гэж хэлсэн бөгөөд одоо ажиллаж байгаа нягтлан бодогч Г.Болор-Эрдэнэ нь дүүргийн төрийн санд хандан байгууллагын баримт бичгээр төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх гэж байгаа тухай хандаад байгаа болно. Төрийн санд тушаасан баримтыг авах хүртэл сургуулийн архивт байх баримтаар данс бүртгэлийг бүрдүүлээ.

-70 жил хадгалагдах баримтын бүрдлийн хувьд: цалингийн карт, захирлын “Б” тушаал, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны хуудас зэрэг баримтуудаас бүрдэж байна.

-Түр хадгалагдах баримтын бүрдлийн хувьд: Ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдол, бэлэн мөнгөний орлого, зарлага, касс, харилцах, цалингийн баримтууд, “Үдийн цай” хөтөлбөрийн тооцоо, няравын тайлан, аж ахуйн гэрээ, санхүүгийн улирлын тайлан тэнцэл, үндсэн хөрөнгийн хагас жилийн тооллогын бүртгэл зэрэг баримтуудаас бүрдэж байна.

Ангийн журналын бүртгэлийг тусад нь ангилан бүртгэлээ.

ЭШТБ-ын ажлын явцад:

1.1992-2012 оны задгай баримтуудыг нягтлан шалгаж, ангилан ялгаж, захирлын тушаалыг 2008 оноос үйл ажиллагааны болон боловсон хүчний асуудлаар 2 ангилан он, сар, өдрийн дараалалд оруулж, хуудас дугаарлах, үдэж хавтаслах, нуруу цаас наах, нүүр бичилт хийх, сэлбэн засах зэрэг техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2. Ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдлыг ач холбогдол, хадгалах хугацаагаар нь байнга, түр болгож ангилан, хэрэг бүрдүүлж авсан.

3 . 2003 оноос хойших санхүүгийн тайлан тэнцэл, татварын тайлан, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан зэрэг нь санхүүгийн баримтад хамт үдэгдсэн, хадгалах хугацаа нь дуусаагүй тул задлалгүй түрийн бүртгэлд нь үлдээв.

4. 1992-2002 оны касс, харилцахын баримт, хүнс материалын тайлан, үндсэн хөрөнгө, эд хөрөнгийн хагас жилийн тооллогын бүртгэл баримтууд, шалгалтын материал, хөдөлмөрийн гэрээ зэрэг холбогдох баримт бичгүүдийг нягтлан шалгаж хадгалах хугацаа дууссан, түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 21 хэргийн 116 хадгаламжийн нэгж, 46208 хуудас задгай баримтыг устгах хэргийн акт үйлдсэн.

5. ЭШТБ-ын ажлыг хийх явцад 1992-2012 оны байнгын баримтын дансыг бүртгэн Нийслэлийн Архивын газарт хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.

ЭШТБ-ын ажлын үр дүнд:

- 1992-2012 оны 209 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 1992-2012 оны 156 хадгаламжийн нэгж бүхий түрийн бүртгэл,
- 1993-2012 оны 38 хадгаламжийн нэгжийн 70 жилийн бүртгэл,
- 1993-2012 оны 1036 хадгаламжийн нэгжийн журналын бүртгэл,
- 1992-2007 оны эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 21 хэргийн 144 хадгаламжийн нэгжийг устгах устгах хэргийн актыг тус тус үйлдэв.

Дээрх данс, бүртгэл, актыг Баянзүрх дүүргийн 97 дугаар сургуулийн дэргэдэх БНШК-ийн 2013 оны 12 дугаар сарын 11-ний 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ийн хурлаар оруулахаар шийдвэрлэв.